

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 10 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд томоохон хөгжлийн төслүүдийн барилга, угсралтын ажлыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын санхүүжилтыг тусгаснаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлэх бодлогыг хэрэгжүүлэх, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн зарим тусгай шаардлагыг өөрчилсөнтэй холбоотойгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг тооцсон аргачлалын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан дүгнэлтээс зөрүүтэй байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг бодитой тооцсон эсэх болон Монгол Улсын ажиллах хүчний тоо 2025 онд буурах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар биржээр борлуулж байгаа нүүрс сүүлийн саруудад буурсан шалтгаан, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат 2025 онд иргэдийн бодит орлого хэрхэн өсөх болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, Ц.Даваасүрэн нар Улсын Их Хурлаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төслийн талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тусгайлан хэлэлцдэг байх, тухайн жилийн төсөв болон төсвийн тодотголтой хамт төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Ганбаатар нар биржээр борлуулж байгаа нүүрсний хэмжээг бууруулахгүй байхад анхаарч биржийн үйл ажиллагаанд брокеруудыг оролцуулдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН